





Хайку шүлгийн тухай сонссон уу? Хайку шүлгийн талаар юу мэдэх вэ?

“Эртний цөөрөм

Аниргүйд цүлхийх чимээ

Мэлхий үсэрсэн аж”

Яруу найрагч хавар цөөрмийн дэргэд сууж байна гээд төсөөл. Гэнэт нам гүмийг эвдэн ус цалгих дуулдав. Мэлхий үсэрсэн аж... Энэ агшин өөрт тань төсөөлөгдөж байна уу? Ямар мэдрэмж төрж байна?

Хайку

$$5 + 7 + 5 = 17 \text{ үет}$$

Э-рт-ний цөө-рөм
А-нир-гүйд цүл-хийх чи-мээ
Мэл-хий ү-сэр-сэн аж”

“Хайку бол байгалийн тухай бүтээлч зураглал юм” гэсэн дэгийг ягштал баримталдаг. Тиймээс байгаль улирлыг илэрхийлсэн үгтэй байх ёстой гэж үздэг. Хайкуд илүү үг байх ёсгүй, санаагаа 3 мөрөнд багтааж бичдэгээрээ онцлогтой. Хайкуд түлхүүр үг гэсэн ойлголт байдаг ба тухайн үгээр хайкуг тайлж уншиж үндсэн санааг нь гаргадаг. Тухайлбал жавар гэдэг үг шууд дүн өвлийг заадаг. Тиймээс энэ үг хайкуд орсон бол өвөл, дүн өвөл гэсэн үгийг бичих шаардлагагүй, жавар гэсэн үгнээс уншигч энэ өвлийн улирлыг илэрхийлж байгааг ойлгоно.





Мацуо Башё

Хайку шүлгийг үндэслэгч, яруу найрагч Башё хайку хэлбэрийн яруу найргийг өөрийн уран бүтээлээр цэцэглэлтийн дээд шатанд гаргаж, “Башёгийн сургууль” буюу өөрийн арга барилыг дагагч олон яруу найрагчийг төрүүлсэн. Башёгоос өмнөх үеийнхэн зөвхөн байгалийг л зурагладаг байсан бол Башё хайкуд гүн ухааныг авчирснаар энэ богино мөртүүд жинхэнэ яруу найргийн төлвийг олсон гэж үздэг.

Зохиолыг хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлбэ



Хуучин цөөрөм рүү
Хөөрхий малхий дээхрэхэд
Усны чимээ гарав.
хх хх хх
Нүцгэн мөчир дээр
Нэвсгэр хэрээ сууж байгаа нь
Намрын үдэш санж.
хх хх хх
Аймшигт ядуу эр
Амуу цайруулахва болиод
Онгон сарыг ширтэв.
хх хх хх
Яг замын хажууд
Ягахан цэцэг дэлгэрчээ.
Яая гэхэв, морь минь идчихлээ!
хх хх хх
Хэрвээ би яваган явсан бол
Хээрийн энэ толгод дээр
Мориноосоо юу гэж унах вэ дээ.

Өвч биеийн сүүдэр
Эмээл дээрээ царцах нь
Өвлийн нарны илч аж.
хх хх хх
Аяа, хувь зохиол гэж хачин юм даа
Алдарт энэ дуулган дотор эдүгээ
Адгийн хүрэлзгэнэ дуугарч байна шүү.
хх хх хх
Мөчрөөс мөчирт
Мөлхөн урсах нь
Хаврын бороо ажээ.
хх хх хх
Өвлийн өгтөө аюоны цасан дээр
Өөдгүй хэрээ ч
Өнгө засжээ.

- Хайку шүлгийг уншаад юу мэдрэв? Чамд ямар санагдав?
- Шүлэгт ямар агшныг буулгасан вэ?
- Зохиолд юуг голлон дүрсэлсэн байна вэ?
- Хайкуг гүн ухааны шүлэг гэж хэлж болох уу?
- Хайкуд зохиолчийн мэдлэг, ухаан бодол, эргэцүүлэл чухал байна уу? эсвэл мэдрэмж чухал байна уу? Чи юу гэж бодож байна?
- Хайку шүлэгт ямар хам сэдэв илүү туссан гэж үзэж болох вэ?

Далд утгыг хэрхэн тайлбарлав?

Нүцгэн мөчир дээр – намар нэлээд орой болж

Хэрээ суув - Ширхэг ч навчгүй бараан мөчир, хар шувуу, үдэш бүхий л орчлон өнгөө алджээ.

Намрын үдэш – нам гүм агшин


Байгалийн төрх хүний сэтгэлийн хязгааргүй гүн гунигийг илтгэнэ.
Хэрээ биш, яруу найрагч ганцаарджээ.

Үхмэл, нүцгэн мөчир дээр суугаа ганц хэрээ нэг л ер бусын, энэ хорвоогоос тасран одсон мэт сэтгэгдэл төрүүлдэг. "Орой намар", "Намрын үдэш" гэсэн утгаас дуусч байгаа зүйл, төгсгөл хан хийтэл, маш хурц үнэртэнэ. Хачин нууцлаг, ёроолгүй ангал шиг хязгааргүй уудам энэ амьдралыг ингэж мэдрэхэд үүнээс олон үг, урт найраглал хэрэггүй

Зохиолч, яруу найрагч Г. Аюурзана



Далд утга



Далд утгатай үгс

Дүрслэх ур маяг

Бэлгэдэл

Далд утгыг хэрхэн тайлбарлав?

Хуучин цөөрөм рүү Хөөрхий мэлхий дэвхрэхэд Усны чимээ гарав

“Хуучин цөөрөм” хайку нь хаврын тухай шүлэгт холбогдох бөгөөд яагаад гэвэл “мэлхий” гэдэг нэр бол хаврын улиралд их яригддаг “улирлын чанартай үг” юм. Япончуудын заншил ёсоор мэлхийн дууг хамгийн сайн сайханд тооцдог ажээ. Алтан гургалдайн дуу ямар сайхан юм бэ, түүнтэй нэгэн адил үзэж хаврын мэлхийн анхны дууг япончууд тэсэж ядан хүлээдэг байна. Энэ нь зуны эхэн сарын хөхөөний анхны дууг монголчууд тэсэж ядан хүлээдэгтэй яг адил юм.

Яруу найрагч Б.Явуухулан

Мэлхий үсрэх, ус цүл хийх чимээ орчин тойрны нам гүмийг хэрхэн эвдэхийг Башё олж харсан хэрэг. Хэрэв цочоох чимээ гарахгүй бол хязгаар эцэсгүй нам гүмийг хэн ч анзаарахгүй. Зэнгийн үүднээс, нам гүм, чимээ анир хоёр хамтдаа ертөнцийг бүхэлд нь илтгэнэ. Нам гүм бол ахуйн аар саар хүсэл шуналаас нэгэнт ангижирсан дотоод сэтгэлийн бэлгэдэл. Гэвч тэр нам гүмийг танихад чимээ хэрэгтэй. Нөгөө талаас энэ хайку цаг хугацааны тухай эргэцүүлэл. Эртний цөөрөм бол үүрдийн, тийш үсэрсэн мэлхий бол зуурдын санааг бэлгэдэж байна. Шүлэгт өнө мөнхийн болоод агшин зуурын мөн чанар нэг дор илэрхийлэгджээ. Гэхдээ мэлхий үсрэхийг сэрсэнийхээ дараа ахиад л нам гүм, ахиад л өнө мөнхийн чанарт яруу найрагч шургав. Тэр юунд ч автаж, хаашаа ч хэлбийлгүй, бүхнийг буй байгаагаар нь л харж үгүүлж байна.

Зохиолч, яруу найрагч Г.Аюурзана

Эртний цэцэрлэг ч юм уу аглаг зэлүүд хөвчийн гүнд орших цөөрөм, хаврын халуун өдрийн нам гүмийн зургийг зурахдаа байгалийн манхийн гоо сайхны тухай, түүний дундах мөнх бусын ганц эгшинг дүрслэх гэсэн далд бясалгалын санааг шингээжээ.

С. Дулам “Уянгын учир” УБ, 1988 он

“...агшин зуурын хийгээд өнө мөнхийн зүйлсийг Башё нэгтгэж чаджээ. Хуучин цөөрөм бол мөнх, мэлхий үсрэх нь яг энэхэн агшинд л тохиох учрал. Гэвч мэлхий үсэрсний дараа цөөрөм ахиад л эцэс төгсгөлгүй нам нүмд автаж байна.”

Америкийн утга зохиол судлаач
Дональд Кин

Шүлгийн тайлбар

сүмийн оройгоос

тагтаа нисэхүйд...

дурсамж сэргэнэ

Энэхүү хайкуд өгүүлэгдэж буй "сүмийн орой" уламжлалыг илэрхийлсэн байхад "тагтаа" шинэчлэлийг илэрхийлсэн байна. Уламжлал ба шинэчлэл нь мөн эсрэгцэл болоод дурсамжаар эдгээрийн уялдааг холбоог харуулжээ.

“цэцэгс...

цаг хугацааны хугаралд

хагдарч үзэгднэм “

Бидний нүдэнд хагдран үзэгдэж байгаа цэцэгс мөн чанартаа хамгийн үзэсгэлэн гоо, төгс төгөлдөр шинжийг агуулсан байгаа. Үзэгдэх зүйл бол, өнгө бол хуурамч, цаг хугацаа ч бас хуурамч. Бидэнд харагдахгүй байгаа олон олон зүйлс мөн чанартаа хамгийн шударга, бас хамгийн үнэн байх" хэмээн тайлсан байна.

- Шүлэгт ямар далд утга байж болох вэ?
- Үг бүрийн цаадах үндсэн утгыг эргэцүүлээрэй.

Үдшийн цахирмаа...
Цагаахан дэлбээ анхилам
үнэрт нуугджээ

Ё. Бусон (үнэр, өнгөний
хослол)

Цагаан удвал цэцэг
түүний үнэр гэрэл цацруулам,
бас сүүдэртэй

Рюносукэ (үнэр ба
өнгөний хослол) нэг
өгүүлэмжийг өөр өгүүлэмжтэй
эсрэгцүүлсэн.

Хэзээ ч мартагдахгүй
Ганцаардлын амт
Цагаан шүүдэр

М. Башё (амт үнэрийн
хослол)

Аагим зунаар...

Хүйтэн горхи мэт анхил охид
зөрөн өнгөрнө

Н. Идо

Зохиогч аагим халуун, хүйтэн
горхи гэсэн хурцхан эсрэгцлийг
чадамгай ашигласан байна.

Сүмийн оройгоос
Тагтаа нисэхүйд...
Дурсамж сэргэнэ.

Г.Дарьям

Хайкуд өгүүлэгдэж буй “сүмийн орой”
уламжлалыг илэрхийлсэн бол “тагтаа”
шинэчлэлийг илэрхийлсэн байна.
Уламжлал ба шинэчлэл нь мөн эсрэгцэл
болоод дурсамжаар эдгээрийн уялдааг
холбоог харуулжээ.

Хайку нь зохиогчийн уран сэтгэмж, мэдрэмж, гүн ухааны үзэл болон уншигчийн туршлага, уран сэтгэмжийн цогц нийлбэр юм. Тиймээс шүлгийн утга санаа нь уншигчийн сэтгэл хөдлөлийн байдал, үзэл бодол зэргээс шалгаалан маш олон янзаар тайлагдаж болно.

Ямар нэгэн агшин ямар нэгэн эгзэг бол хайку шүлгийн бодит болон хийсвэр нөхцөл нь юм. Тиймээс Хэзээ ? Хаана ? Яагаад ? Ямар учраас ? гэсэн эргэцүүлэлгүйгээр хайкуг тайлан ойлгож болохгүй.

Зохиолд дүрслэгдэж буй орон зай, цаг хугацаа



- ◆ Бодит болон хийсвэр орон зайн нөхцөл байдал
- ◆ Байгаль, цаг улирлын үзэгдэл, өөрчлөлтийн нэг агшин
- ◆ Цаг хугацааг шууд (“өвлийн үдэш”, “зуны төгсгөл” унжсан мөс” хаврыг, “усан үзэмний хураалт” зуны төгсгөлийг) болон шууд бусаар заадаг.
- ◆ Бүх үйл явдал одоо цагт яг тэр мөчид болдог гэж үздэг учраас өнгөрсөн, ирээдүй цагийн үйл явдал дүрслэгддэггүй .



Зохиолын гадаад орчин

Зохиолын гадаад орчин

Зохиолч тодорхой зорилгоор дүрийн мөн чанарыг илэрхийлэхийн тулд ямар нэгэн орчин орон зайг дүрсэлдэг . Үйл явдал хэзээ хаана өрнөж байгааг заана.

Дотоод орчин

Зохиолын үйл явдал өрнөх, дүрүүдийн амьдрах тэр цаг үеийн нөхцөл байдал болон дүрүүдийн хоорондын харилцааны уур амьсгалыг тодруулсан байдлыг хэлнэ

Зохиолд ихэвчлэн байгалийн

Эртний цөөрөм

Аниргүйд цүлхийх чимээ

Мэлхий үсэрсэн аж” - мөнх бус оршихуйн тухай, уйтгар гунигийн тухай, хайр дурлалын тухай өгүүлсэн.

Нүцгэн мөчир дээр хэрээ сууна намрын үдэш----- хүний сэтгэлийн уйтгар гунигийг илэрхийлсэн.

Хүн ба байгаль ертөнц хоёрын холбоог харуулсан.

Дүгнэлт

- ◆ Хайку нь таавартай байх ёстой ба уншигчийг гоо сайхан, сэрэл мэдрэмжид хөтлөн цааш нь ургуулан бодох орон зайг уншигчдаа үлдээх ёстой гэж үздэг. Хайку бүхнийг хэлэх ёсгүй, хайкуг уншиж байгаа уншигч өөрийн үзэл бодол, сэрэл мэдрэмж, уран сэтгэмжээр баяжуулан, түүний нэгээхэн хэсэг болдгоороо онцлог юм.
- ◆ Орон зайг хураан хязгаартай орчинд хязгааргүйг багтаах